**БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

Анхдагчдын өргөн чөлөө, 1-120 Жаргалант,
5 дугаар баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2244
Цахим шуудан: sankhuu_audit_bu@yahoo.com
Цахим хуудас: Sankhuu Audit Bulgan

2024.09.17 № 52

танай ______ -ны № ______ -т

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ

Манай албанд ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2024 оны III дугаар улирлын байдлаар гаргаж хүргүүлэв.

ДАРГА Б.БАТТУЛГА

2193136 0424010022 БТ5454

TootA5

# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА

**2024.09.17**

2024 оны 3-р улирлын байдлаар нутгийн захиргааны байгууллагад хандаж гаргасан 6 хүсэлтийг хүлээн авсан.Үүнд:

Булган Соёл урлагийн газраас Аймгийн Хөгжимт жүжгийн театрын даргын хууль зөрчиж ажиллаж байгаа тухай шалгуулах хүсэлт

Булган аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Аймгийн Хөгжимт жүжгийн театрын даргын хууль, тогтоомж зөрчсөн үйлдэлтэй холбоотой гомдлын дагуу санхүүгийн зөрчил гаргасан асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт

Монгол улсын Зам тээврийн хөгжлийн яамнаас "Булган Азза" ТӨХК шалгуулах хүсэлт

Авлигатай тэмцэх газраас Булган аймгийн Бугат сумын засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Ч.Одонтуяаг шалгуулах хүсэлт

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Сургуулийн захирал Ж.Ариунаагаас сургалтын менежер Дүүрэнжаргалыг шалгуулах хүсэлт

Хишиг-Өндөр сумын ИТХ-н нарийн бичгийн дарга Д.Ганчимэгээс ажилчдын орон нутгийн нэмэгдэл дутуу олгосонг шийдвэрлэх хүсэлт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБА

**Хүснэгт №1**

## 2024 оны III-р улирлын байдлаар иргэдээс Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

| Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт /Хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | | |
| СХДАА | 6 | 5 | | | 1 | 83,3% |
| **Сумын нийт дүн** | **6** | **5** | | | **1** | **83,3%** |

**Хүснэгт №2**

## 2024 оны III-р улрилын байдлаар иргэдээс СХДААлбанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

| Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдлын тоо | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| СХДАА | 6 | 5 | | 1 | | |
| **Сумын нийт дүн** | **6** | **5** | | **1** | | |

**Хүснэгт №3**

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

| | | |
|---|---|---|
| 1 | Булган | Нийт **6** өргөдлөөс 1. Хүсэлт – 6 / 100%<br>2. Санал – 0 / 0%<br>3. Гомдол – 0 / 0%<br><br>1. Санхүүгийн зөрчилтэй холбоотой<br>1. Булган аймгийн Соёл урлагийн газраас Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрыг шалгуулах хүсэлтэд санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар 788,5 мянган төгрөгийг төсвийн орлого болгохоор улсын ахлах байцаагчийн 2 акт тогтоож, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж таслан зогсоохоор улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлагыг хүргүүллээ. Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>2. Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлөөс Булган аймгийн Хөжгимт жүжгийн театрыг шалгуулах хүсэлт- Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар 788,5 мянган төгрөгийг төсвийн орлого болгохоор улсын ахлах байцаагчийн 2 акт тогтоож, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж таслан зогсоохоор улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлагыг хүргүүллээ. Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>3. Монгол улсын зам тээврийн хөжлийн яамнаас Булган АЗЗА ТӨХК шалгуулах хүсэлт- шалгалтын хугацаанд санхүү бүртгэлийн ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын ахлах байцаагчийн актаар 1,181,818.19 төлбөр тогтоов.<br>4. Авлигатай тэмцэх газраас Булган аймгийн Бугат сумын засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Ч.Одонтуяаг шалгуулах хүсэлт- Фэйсбүүк хаяг дээрх хандив өгсөн байдал нягтлан бодогчийн гаргасан хандивын орлогын тайлан нь 15 иргэн, ААН-ийн хандив 1,740.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө, 4 иргэнээс хандивласан 6 ширхэг хонь , 2-р багийн иргэн Д.Нямсүрэн гэр бүлээс хандивласан 1 ширхэг ямаа, 1-р багийн малчин Т.Түвшиннямын гэр бүлээс хандивласан- 3 ширхэг ямаа, бусад 4 иргэн, нөхөрлөлөөс хандивласан 1 шуудай төмс, лууван-2 шуудай , сонгино-1 шуудай, хэрчсэн гурил-10 уут, талх-8 ширхэг, 4 хайрцаг хүнсний бүтээгдэхүүн, Б.Эрдэнэцогтоос хандивласан 1,000.0 мянган төгрөгийн шатахуун байгаа боловч эдгээр хандивыг орлого авч, зарлага гаргасан анхан шатны баримтгүй, данс бүртгэлд тусгаагүй, нягтлан бодогчийн тайланд байхгүй, яаж зарцуулсан нь тодорхойгүй байна. Бугат сумын тамгын газрын нэмэлт 100040255405 тоот дансанд 2021 оны 05-р сарын 20-ны өдөр нярав О.Дуламжав хаанаас хандивласан нь тодорхойгүй бэлэн мөнгө 3,135.0 мянган төгрөгийг тушаасан байгаа ч хаанаас хэн хэчнээн төрөг хандивласан нь тодорхойгүй байна. Иймд Шинжээч томилон шалгах<br><br>5. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын сургуулийн захирал Ж.Ариунаагаас сургалтын менежер Дүүрэнжаргалыг шалгуулах хүсэлт- шалгалтын хугацаанд санхүү бүртгэлийн ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын ахлах байцаагчийн 1 актаар 2282078 төгрөгийн төлбөр тогтоов.<br>6. Хишиг-Өндөр сумын ИТХ-н нарийн бичгийн дарга Д.Ганчимэгээс ажилчдын орон нутгийн нэмэгдэл дутуу олгосонг шийдвэрлэх хүсэлт- хугацаа болоогүй |
| | | |